



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

ddal оны 12 сарын 30 өдөр

Дугаар Ak8d

Улаанбаатар хот


### Журам шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, няглан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /М.Санжаадорж/-т, журмыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж, мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/-т тус тус даалгасугай.

3.Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын “Журам батлах тухай” 2012 оны 238, “Журам батлах тухай” 2017 оны 216, “Журам шинэчлэн батлах тухай” 2019 оны 74, “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2022 оны А125 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



9763000896

Сангийн сайдын 2022 оны 11 дугаар  
сарын 30-ны өдрийн 11:00 дугаар  
тушаалын хавсралт

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЭМНЭЛТ, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭМЭЛТ  
ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГАХ,  
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах талаар төсвийн ерөнхийлөн захирагчийн идэвх санаачилгыг дэмжих, үйл ажиллагааны үр дүн, төсвийн гүйцэтгэлийг үндэслэн төсөвт байгууллагуудын төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавихад энэ журмыг мөрдөнө.

1.2. Энэ журам нь бүх шатны төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарна.

1.3. Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг тодорхойлох, зарцуулах, тайлагнахад дараах зүйлсийг мөрдлөг болгоно:

1.3.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

1.3.2. нэг удаагийн шинж чанартай зардлын хэмнэлт, эсвэл үйл ажиллагааны орлогын эх үүсвэрээр тогтмол буюу нэг ба түүнээс дээш төсвийн жилд хэрэгжих үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх;

1.3.3. шийдвэр гаргах, тайлагнах, хяналт тавихад байгууллагын нийт хамт олны оролцоог хангах;

1.3.4. төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;

1.3.5. төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх.

1.4. Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалт, тайлагналтыг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ.

1.5. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг бусад төсөвт байгууллага, хуулийн этгээд, хувь хүнд шилжүүлэх, олгох зэргээр зарцуулахыг хориглоно.

1.6. Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой тооцож төсөвт тусгуулах ба хэрэв үндэслэлгүй төлөвлөгөө батлуулсан нь нотлогдвол энэ журамд заасан зарцуулах эрх олгохгүй.

**Хоёр. Төсвийн зарлагын хэмнэлт**

2.1. Төсвийн тухай хуулийн 45.1-д заасан төсвийн жилийн эхнээс өссөн дунгээр тооцож гаргасан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл буюу зарлагын хэмнэлтийг

санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж (аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон нутгийн санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгж) хариуцсан тухайн жилийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах арга хэмжээ авч зарцуулах эрх олгоно.

2.2. Төсвийн зарлагын хэмнэлтийг тодорхойлохдоо энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан маягтыг ашиглах ба дараах баримт бичгийг хавсаргасан байна:

2.2.1. Төсвийн тухай хуулийн 45.1.1-45.1.4, 45.1.6-д заасны дагуу зардал хэмнэсэн бол холбогдох тооцоолол, тайлбарын хамт;

2.2.2. Төсвийн тухай хуулийн 45.1.5-д заасны дагуу бүтцийн өөрчлөлтөөр байнгын шинжтэй орон тоо, цалингийн зардал хэмнэсэн бол эрх бүхий байгууллагын шийдвэр, түүнийг хэрэгжсэнийг нотлох баримт, тооцоолол;

2.2.3. шаардлагатай бол өр, авлагын мэдээ, тооцоо нийлсэн акт;

2.2.4. төсвийн зарлагын хэмнэлтийг зарцуулах санал (Төсвийн тухай хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан арга хэмжээнд зарцуулах бол байгууллагын хамт олны хурлын тэмдэглэл, хуралдааны шийдвэрийн хамт).

2.3. Төсвийн зарлагын хэмнэлт бий болгох зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно:

2.3.1. тухай зардлын зүйлийн ангилалд төлөвлөх боломжтой байсан зардлыг өөр зардлын зүйлийн ангилалд шилжүүлэн төлөвлөж, батлуулах;

2.3.2. жилийн төсвийн болон сар, улирлын хуваарийг жигд бус төлөвлөж батлуулах.

2.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.2-т зааснаар үүссэн хэмнэлтийг зарцуулахгүй бөгөөд улс, орон нутгийн төсвийн дансанд шилжүүлнэ.

### **Гурав. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого**

3.1. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод Төсвийн тухай хуулийн 47.1.5-д заасан, төсөвт байгууллагын төсвийн жилийн эхнээс өссөн дүнгээр тооцож гаргасан дараах орлогыг тооцно:

3.1.1. төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого;

3.1.2. төсвийн жилийн дундуур шинээр бий болсон орлого;

3.2. Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан орлогыг энэ журмын гуравдугаар хавсралтад заасан үйл ажиллагаанаас олсон орлогын хүрээнд хамааруулж үзнэ.

3.3. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод дараах орлогыг хамааруулахгүй:

3.3.1. нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн орлого;

3.3.2. хууль тогтоомжоор улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр заасан орлого;

3.3.3. төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний үнэ, тарифт орсон өөрчлөлттэй холбоотойгоор нэмэгдсэн төлөвлөгөөт орлого.

3.4. Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно:

3.4.1. төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний үнэ, тарифыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, албан ёсны шийдвэргүйгээр нэмэгдүүлэх;

3.4.2 үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах;

3.5. Төсвийн захирагч үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг ирүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.5.1. үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тухай Төсвийн ерөнхийлөн захирагчийн албан бичиг;

3.5.2.энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын тайлан;

3.5.3. үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх талаар зохион байгуулсан ажил, хүрсэн үр дүнгийн тухай танилцуулга, тайлбар, тооцоо;

3.5.4. шаардлагатай бол өр, авлагын мэдээ, тооцоо нийлсэн акт;

3.5.5. үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах санал (Төсвийн тухай хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан арга хэмжээнд зарцуулах бол хамт олны хурлын тэмдэглэл, хуралдааны шийдвэрийн хамт);

3.5.6. туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого, гарсан зардал, ашгийн тооцоо, танилцуулга, нотлох баримт.

3.6. Энэ журмын 3.1.1-т заасан орлогын сүүлийн гурван жилийн гүйцэтгэл болон 3.1.2-т заасан орлогын үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалzan төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ.

### **Дөрөв. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг хянан шийдвэрлэх**

4.1. Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг дараах хугацааны дотор хянан шийдвэрлэнэ:

4.1.1. төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрт харьяалагдах төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн саналыг нэгтгэн хянаж энэ журмын 5 дугаар зүйлд заасан баримт бичгийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж (цаашид

“төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж” гэх)-д жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлнэ;

4.1.2 төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж төсвийн өрөнхийлөн захирагчаас ирүүлсэн хүсэлтийг орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл болон энэ журмын 3.2, 3.3, 3.4-д заасантай нийцэж байгаа эсэхийг хянан баталгаажуулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж (цаашид “төсвийн төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж” гэх)-д жил бүрийн “11 дүгээр сарын 13-ны дотор” хүргүүлнэ;

4.1.3. төсвийн төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж нь төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгжээс хянаж ирүүлсэн төсвийн өрөнхийлөн захирагчийн хүсэлтийг энэхүү журамд нийцүүлэн эцэслэн хянан баталгаажуулж, жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор Сангийн сайдын тушаалаар шийдвэрлүүлж, төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ;

4.1.4. төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж Сангийн сайдын тушаалыг үндэслэн төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах эрх нээн санхүүжүүлнэ.

4.2. Орон нутгийн төсөвт байгууллага энэ журмын 3.1.1-т заасан орлогыг зарцуулах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн алба (цаашид “орон нутгийн санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгж” гэх) энэхүү журмын 4.1-д заасан хугацааны дотор хянаж тухайн шатны Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлнэ.

4.3. Энэ журмын 3.1.2-т заасан төсвийн жилийн дундуур шинээр бий болсон нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж (орон нутгийн төсөвт байгууллагын хувьд орон нутгийн санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн) хүлээн авч хянасын үндсэн дээр тухай бүр нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж санхүүжүүлнэ.

4.4. Соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, боловсрол, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төсөвт байгууллагын батлагдсан төлөвлөгөөнөөс давсан орлогыг энэхүү журмын 4.3-т заасны дагуу санхүүжүүлж болно.

#### **Тав. Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалт**

5.1. Төсвийн захирагч төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан журмын дагуу зарцуулах ба төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараах эрэмбийг баримтална:

5.1.1.эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх;

5.1.2. байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах;

5.1.3. нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

5.2. Энэ журмын 5.1.2, 5.1.3-т заасан зориулалтаар зарцуулах хөрөнгийн нийт хэмжээ төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын нийт дүнгийн 60 хувиас хэтрэхгүй байна.

5.3 Хөрөнгийн зардал нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлтөөр тусгагдсан байна.

5.4 Хөрөнгийн зардлыг зөвхөн тухайн оны үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын хэмжээнд тооцож зарцуулах ба дараа онуудад олох орлогыг урьдчилан тооцож, хөрөнгө оруулалтын ажил эхлүүлэхийг хориглоно.

5.5 Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараах эрэмбийг баримтлан хөрөнгийн зардалд зарцуулна:

5.5.1 тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагаанд нэн тэргүүнд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, урсгал засварын ажил;

5.5.2 эдэлгээний хугацаа дууссан тавилга, эд хогшлыг шинэчлэх;

5.5.3 байгууллагын их засвар, бусад хөрөнгийн зардал.

5.6 Төсвийн байгууллага төрийн сангаас гадуур банканд харилцах данс нээсэн, картын дансыг зориулалт бусаар ашигласан, кассаар хийгдэх ажил гүйлгээ, жижиг мөнгөн сангийн үлдэгдлийг байвал зохих хэмжээнээс нь хэтрүүлсэн нь нотлогдвол тухайн төсвийн байгууллагад төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах эрх олгохгүй.

5.7. Орлогын төлөвлөгөөгүй төсөвт байгууллагад үндсэн үйл ажиллагааны нэмэлт төсвийг зарцуулах эрх олгохгүй.

### **Зургаа. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгах**

6.1. Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын явцын мэдээнд оруулж, тухайн тайлант оны санхүүгийн болон үр дүнгийн тайланд тусгана.

6.2. Улсын төсвийн байгууллагуудын нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн яамны Төрийн сангийн газар “хагас жил, жилийн эцсийн байдлаар” Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.

### **Долоо. Хяналт, хариуцлага**

7.1. Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг энэхүү журмын дагуу зарцуулж байгаа эсэхэд дээд шатны байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын нэгж хяналт тавина.

7.2. Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг үр ашиггүй зарцуулсан, мөн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж дараалсан хоёр улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар өр төлбөр үүсгэсэн бол хариуцлага алдсан албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-оОо-

~~Санчийн сайдын 2022 оны дэгээр тушаалаар баталсан журмын нэгдүгээр хөсрөлт~~

~~ПЕЭ-ийн нэр/-ын ... оны эхний /сүүлийн хагас жилийн төсвийн зарлагын Хэмнэлтийн Тайлангийн маягт~~

ОНЫ / Өңгөлөн сабын...

Тайпачи гангасан

.... -ын дарга  
Ерөнхий нягтлан бодог

**Тайланг хянасан:** ТЕЗ-ИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН бодогч

תְּאֵשֶׁת הַמִּזְבֵּחַ וְעֵינָיו בְּבָנָיו

Төсвийн санхүүжилтийн асуудал  
Харин 1сан нааджийн мэргэжийгтэн

**Санчийн сайдын 2022 оны дэлхийн дулаар тушаалаар  
баталсан журмын хөрдүгээр хавсралт**

..... ТЕЭЗ-ий НҮҮРСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭМЭЛТ ОРДОЛГИХ ТАЛЛИГИЙН МАЯГТ

ОНЫ ... дұғаар сарын ...

(десертный гарнитур)

Тайлан гаргасан:

.... -ын дарга  
Ерөнхий нягтлан бодог

**Тайланг хянасан:** ТЭЗ-ИЙН ЕРӨНХИЙ НЯГЛЛАН бодогч

Тайны Небесных Желания

Төсвийн санхүүжилтийн асуудал  
Хариуссан Мэргэжилтэн

Сангийн сайдын 2022 оны 11 дугаар  
тушаалаар баталсан журмын гуравдугаар  
хавсралт

**Төлөвлөгөөнөөс давж биелсэн орлогыг урсгал дансаар хуваарилахад баримтлах үйл  
ажиллагааны төрөл**

№	Үйл ажиллагаа
1	Төрийн аудит, санхүүгийн зохицуулалтын үйлчилгээ
2	Мэргэжлийн хяналтын лабораторийн үйлчилгээ
3	Оюуны өмчийн газрын үйлчилгээ
4	Төсвийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэхээс бусад тогтмол үзүүлдэг ажил, үйлчилгээний орлого /бүртгэл, лавлагаа, үйлчилгээний төлбөр хураамж, түрээс, сургалт, акц, сорил, баталгаажуулалт/
5	Төсвийн байгууллагын туслах үйл ажиллагаа
6	Замын сангийн төлбөр хураах цэгийн үйл ажиллагаа
7	Нэмэлт санхүүжилтийн дансаар хуваарилахад баримтлах үйл ажиллагаанд заагдаагүй бусад үйл ажиллагаа

**Төсвийн жилийн дундуур шинээр бий болсон орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар  
хуваарилахад баримтлах үйл ажиллагааны төрөл**

№	Үйл ажиллагаа
1	Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээ
2	Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаа /усан спорт сургалтын төвүүд, спорт заалны үйлчилгээ г.м /
3	Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ
4	Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага / сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа
5	Боловсролын үнэлгээ, мэдээлэл болон бусийн арга зүйн төвийн үйл ажиллагаа
6	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусlamж үйлчилгээ, түрээсийн үйлчилгээ, хамтын төлбөр
7	Цагдаагийн гэрээт харуул хамгаалалтын зарим үйлчилгээ
8	Олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээн авсан дэмжлэг, техникийн тусlamж
9	Гадаадын зээл тусlamжийн төслийн хүрээнд санхүүжүүлсэн хөтөлбөр арга хэмжээ
10	Төрийн бусад байгууллагад нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний орлого нь тухайн нийлүүлсэн бараа, ажил, үзүүлсэн үйлчилгээний өртөг зардлыг нөхөн хэмжээнд байсан бол
11	Төлөвлөх боломжгүй, гэнэтийн шинжтэй нэг удаагийн төлбөртэй зохион байгуулдаг арга хэмжээ /бүртгэл, лавлагаа, үйлчилгээний төлбөр хураамж, түрээс, сургалт г.м /